

(ШҮҮМЖ)

Гомигава Дзюньпей

**НОМОН ХАН. Токио, 1977**

«Номонханы хэрэг явдал» милитарист японы ялагдлаар төгссөнөөс хойш 40 жил болоод байна. Энэ хугацаанд тэрхүү хэрэг явдлын тухай буюу түүнтэй холбогдол бүхий ном зохиол Японд нилээд гарсан байна. Тэдгээрийн нэг бол цэргийн сэдэвт ном зохиол нилээдийг туурвисан Гомигава Дзюньпей бичиж, японы «Бунгэй сюнью» хэмээх сэтгүүлийн газраас 1977 онд хэвлэн нийтэлсэн «Номонхан» гэдэг ном юм. Зохиогч 85 хэсэг, 340 гаруй тал хуудаснаас бүрдсэн номоо японы албан ёсны бичиг баримт, хүмүүсийн дурдатгал, урьд өмнө гарсан зарим ном зохиолд тулгуурлан бичжээ. Энэ ном Халх голын дайны үед японы тал ямаршуухан байдалтай байж, уг дайн хэрхэн төгссөн тухай японы уншигчдад танилцуулж чадахуйц баримтат бүтээл болсон гэж үзэж болохоор байна.

Хоёр талаас оролцсон цэргийн тоо, түүний төрөл анги, хэрэглэсэн зэвсэг, техник, стратеги тактик, үргэлжилсэн хугацаа зэргийг нэгтгэн үзвэл Халх голын дайн нь гучаад онд Алс Дорнодод болсон томоохон дайн байв. Гэтэл түүнийг жирийн нэг «хилийн будлиан» мэтээр дүрслэхийг японы зарим эрдэмтэд оролдсоор иржээ. Тухайлбал «Номонханы хэрэг явдал» гэгч нь хилийн будлиан төдий биш, харин империалист японоос БНМАУ-ын эсрэг хийсэн зарлаагүй түрэмгий дайн байсныг Д. Гомигавагийн номд иш татсан баримтууд нотолж байна. Дашрамд хэлэхэд Монгол, Япон хоёр нь одоо ч, 1930-аад оны үед ч хил залгаагүй учир хоёр орны хооронд хилийн будлиан гарах шууд үндэсгүй юм.

Японы Кантотё (Кантоны танхим)\* хэмээх байгууллагаас 1934 онд зохиосон газрын зурагт Халх голын зүүн хэсгийг «Манжуур-монголын хилийн шугам», 1935 онд мөн байгууллагаас гаргасан газрын зураг дээр Халх голыг бүхэлд нь «Хилийн шугам» гэж заасан ба 1937 онд Квантуны армийн жанжин штабаас гаргасан газрын зураг дээр Халх голын зүүн хэсгийг «хилийн шугам» гэж дахин тэмдэглэсэн байна. (15 дахь тал).

Японы милитаристууд БНМАУ ба японы тоглоомын улс «Маньчжоуго» хоёрын хилийн шугамыг Халх голоор тогтоохыг оролдсон нь юуны өмнө тэд манай улсын нутаг дэвсгэрээс тодорхой хэмжээний газрыг булаан эзлэхээр улайрч байсан төдийгүй, БНМАУ-ыг бүхэлд нь булаан эзэлж, улмаар манай орныг ЗХУ-ын эсрэг түрэмгийлэл үйлдэх талбар болгохыг санаархаж байлаа. Гэвч уг оролдлого нь биелээгүйг Халх голын дайны төгсгөл харуулсан учир Халх голын дайн Япон улсын хувь заяанд чухал сургамж болсон тухай зохиогч хөндсөн байна. «Алс холын Номонханы хээр талд нүргэх буун дуун японы хувьд гэвэл хувь заяаны хаалгыг балбасан дуу байлаа. Японы удирдагчдад тэр дууг сонсож ялгах чих байсангүй» гэж бичжээ. (11-р тал). Халх голын дайн бол японы арми биеэр үзсэн орчин үеийн анхны дайн бөгөөд социалист орнуудын эсрэг

\* Гадаадад түрэмгийлэл үйлдэх асуудлыг эрхэлж байсан байгууллага

түрэмгийлэл үйлдвэл шившигтэй сүйрлээр төгсөнө гэдгийг империалист харгис хүчинд хатуу анхааруулсан юм.

Гэвч японы милитаристууд богино хугацаанд Зүүн Хойт Хятадыг бүхэлд нь эзэлж «Маньчжоу-го» хэмээх тоглоомын улс байгуулан, мөн умарт ба дорнот Хятадын нилээд хэсгийг эзэлж авсандаа улангасан сагсуурч, манай батлан хамгаалах хүчийг басамжлан тооцож, Монгол-зөвлөлтийн ах дүү армийн хүчин чадлыг буруу үнэлж байжээ.

Цудзи Мосанобу гэгч Халх голын дайны тухай дурдатгалдаа «Манайхантай бараг адил гэж тооцоолсон дайсны хүч манайхаас нэг дахин илүү байсан ба ялангуяа тооны хувьд давуу танк, хөнөөх чадал ихтэй их буу нь санаснаас гадуур байсан нь харамсалтай байв» гэж бичсэнийг Гомигава иш татсан байна.<sup>1</sup> (6-р тал).

Тэрчлэн Халх голын дайнд японы талын гол хүч болж орсон 23-р дивизийн дарга Комацу Бара нь «Гадаад Монголыг ганц далайлтаар шударна» (15-р тал) гэж бардамнаж байжээ.

Японы эрх баригчид, самуурайчууд Зөвлөлт, Монгол хоёр улсын эсрэг дайн дэгдээх явдлыг өөрсдийн «Түүхэн зорилго» гэж үзэж байсан ба тэрхүү зорилгоо хэрэгжүүлэхийн тулд тусгай зэвсэгт хүчин-Квантуны армийг байгуулжээ. Энэ армийн хүчин чадлыг зузаатгахын тулд японы зэвсэгт хүчний бусад хэсгээс үлэмж зүйлийг Квантуны армид шилжүүлж байсан юм.<sup>2</sup>

Танака Гиити 1926 онд Япон улсын ерөнхий сайд болмогц юуны өмнө түрэмгийллийн төлөвлөгөө зохиож эзэн хаандаа танилцуулан, 1927 онд «Танакагийн төлөвлөгөө» хэмээн зарлагдсан тэр баримт бичигт БНМАУ-ыг эзлэн авах явдлыг нэгэн гол зорилго болгожээ. Иймд үүнээс даруй 12 жилийн хойно болж буй «Номонханы хэрэг явдал» бол хэдэг дээрээ Танакагийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх тодорхой алхам гэж үзэж болох билээ. Тэр төлөвлөгөөг хэрэгжүүлэх нь Квантуны армийн үндсэн үүрэг байв. Д. Гомигава Халх голын дайны үед дэх японы армийн байдлыг нилээд тодорхой бичсэн атлаа уг хэрэг явдал, Танакагийн төлөвлөгөө хоёрын хоорондох холбоо авцалдааны тухай огт хөндөөгүй нь харамсалтай байна. Энэ нь японы цэргийн гэмт хэрэгтнүүд Токиогийн олон улсын шүүхэд «Танакагийн төлөвлөгөө» гэж байгаагүй<sup>3</sup> гэж мэлзэхийг оролдсонтой шууд холбоотой байж болох юм. Гэхдээ зохиогч «Номонханы хэрэг явдал» хилийн будлиан төдий биш жинхэнэ дайн болсон гэдгийг аргагүй хүлээхэд хүрсэн нь «Номонханы хэрэг явдал» бол жижиг хэмжээний «Номхон далайн дайн» гэж бичсэнээс тодорхой байна. (11-р тал). Халх голын дайнд японы империалистууд тэр үеийнхээ бүх шилдэг зэвсгийг хэрэглэснээс гадна 731-р отрядын бэлтгэсэн бактериологийн зэвсгийг хүртэл хэрэглэснийг дурдаад (98-р тал), ер нь Япон улс ийм дайнд орох ёстой байсан уу, үгүй юу? гэдэг асуудлыг зохиогч хөндсөн байна. «Номонханы хэрэг, явдлыг байгаа байдлаар нь зөв үнэлэсэнсэн бол түүнээс хойш ердөө л 2 жил 3 сарын дараа эхлэсэн их дайнд орох мунхаг хэргийг япон үйлдэх ёсгүй байв» гэж бичжээ. Зохиогч энэ өгүүлбэрийг Япон улс Номонханы дайнд ялагдсан явдал Номхон далайн дайнд ялагдахын урьдчилсан дохио байв гэсэн утгаар бичжээ. Хэрэв Япон улс ерөөсөө дайн хийх ёсгүй байсан гэж хэлэх гэсэн бол «Япон улс Номхон далайн дайнд орох ёсгүй байсантай адил Халх голд ч дайн өдөөх ёсгүй» гэж бичих

<sup>1</sup>Цудзи Мосанобу нь 1937 оноос Квантуны армид шилжин ажиллаж, 1939 онд Халх голын дайн эхлэхээс дуусах хүртэл фронтын үйл ажиллагааг жанжин штабаас удирдаж байсан ба цэргийн гэмт хэрэгтэн юм. (Д.Д.).

<sup>2</sup>Такусиро Хаттори. «Дайтоа сенсо зенси» (Их Дорнод Азийн дайны бүрэн түүх) хэмээх номын орос орчуулгад проф. Г. Гельфондын бичсэн оршлоос.

<sup>3</sup>«Синьчжин цыдянь» (шинэ мэдлэгийн толь), Шанхай, 1952. 134-р тал.

учиртайсанжээ. Гэтэл тэгж хэлэхийг зориглоогүйгээс үзвэл зохиогчийн дээрх өгүүлбэр нь Халх голд Япон улс ялагдал хүлээсэнд харамсах сэгэл төрсөн болохоос биш тэр түрэмгий дайныг жигшин буруушаасан хэрэг биш бололтой.

Халх голын районд БНМАУ-ын эсрэг түрэмгийлэл үйлдэхээр японы милитаристууд эртнээс бэлтгэж байсан ба тодорхой төлөвлөгөөг 1939 оны 4-р сард Квантуны армийн жанжин штаб баталсан ажээ. (15-р тал). «Манжуур-Зөвлөлтийн хилийн маргааныг шийдвэрлэх хөтөлбөр» хэмээх тэрхүү төлөвлөгөөг Квантуны армийн жанжин штабын гол тушаалтны нэг Цудзи Мосанобу зохиожээ. Уг хөтөлбөрийн гол агуулгыг нэг үгээр хэлбэл өдөөн хатгаж мөргөлдөөн үүсгэх явдал байлаа. М. Цудзи өөрийн дурдатгалдаа «Номонхан» хэмээх газрын нэрийг Халх голын дайныг тухирагчдаас хэн нь ч мэдэхгүй байсан мэтээр дурдсаныг Гомигава няцаах журмаар бичжээ.

Зохиогч номынхоо ихэнх хэсэгт дайны явцыг аль болохоор тодорхой бичихийг оролдсон байна. Ялангуяа 7, 8-р сарын тулалдааныг болсон сар, өдөр, газар, анги нэгтгэлийн нэр зааж, тэдгээрийн дарга нарын үйл ажиллагааг хүртэл тоочин бичсэн байна. Үүнээс гадна Японы Хуурай замын цэргийн яамнаас Халх голын дайны талаар гаргасан зарим тушаалын эх бичгийг сийрүүлэн ашигласан байна. Харин эдгээр баримт нь дайныг Япон улс ямар зорилгоор хийсэн ба тэр дайны төлөвлөгөө хэрхэн нурж ялагдал хүлээхэд хүрснийг Халх голын дайны тухай бага мэддэг японы уншигчид бодит байдлаар нь ойлгож зохих дүгнэлт хийх боломж олгосон байна. Японы засгийн газар дайныг ялагдлыг хэрэг дээрээ хүлээж, цаашид үргэлжлүүлэхээс татгалзаж байсан боловч 9-р сарын 2-нд Квантуны армийн командлагч Уэда тушаал гаргаж түүндээ: «Эдүгээгийн тулалдааны утга агуулга нь ердийн хилийн будлианаас бүрэн ялгаатай бөгөөд ялах, ялагдах нь улсын нэр сүрийн мандах ба буурахтай үлэмж холбоотой учир япон-зөвлөлтийн хоорондох нэгэн том шийдвэрлэх тулалдаан мөн бөлгөө.

Эзэнт улсын дотоод, гадаад хэрэг их байгаа намар цаг цэрэг, дарга нар аминч санааг орхиж, төрийн төлөө хэмээх их журмыг барин, заавал ялах итгэл төгс байж түмэн бэрхшээлийг даван туулж эрэлхэг догшин Зөвлөлт-Монголын цэргийг бут ниргэж эзэн хааны армийн сүр хүчийг дотоод гадаадад бадраахыг эрмэлзэнэ» гэж бичжээ (316-р тал).

Дээр дурдсанчлан 8-р сарын 30-нд Японы Хуурай замын цэргийн яамнаас Номонханы дайныг хүчээр өргөтгөх хэрэггүй бөгөөд дайны ажиллагааг түргэн зогсоохыг Квантуны армийн командлалд даалгасан байхад генерал Уэда дээрх тушаал гаргасан нь чухамдаа түрэмгий дайнаа ямар үнээр боловч цаашид үргэлжлүүлэх эрмэлзлэлтэй байсны гэрч юм. Нөгөө талаар Квантуны армийн командлал Токио дахь төвтэйгээ санал зөрөөтэй байсныг харуулж байна.

8-р сарын 20-нд Монгол-Зөвлөлтийн армийн сөрөг давшилт эхлэж японы булаан эзлэгчдэд хатуу цохилт өгснөөс хойш японы армийн дээд командлал самгардалд орж Халх голын дайны холбогдол бүхий олон тооны тушаалууд гаргаж зайлшгүй ялагдах байдлаас мултрахыг оролдсон байна. Нэг үгээр хэлэхэд тэдгээр тушаалууд нь японы милитаристууд өдөөсөн дайндаа өөрснөө ялагдсанаа хүлээсэн акт бичгүүд байлаа. Зөвхөн 9-р сарын 3-ны өдөр 3 тушаал гаргасан нь дайны талбарт орхисон цэрэг, даргын хүүр, буу зэвсгээ цуглуулан авах тухай тушаалууд (322-р тал) байжээ.

Халх голд Японы арми зөвхөн стратеги, тактикийн хувьд хатуу цохилт авсан төдийгүй, самуурайн дийлэгдэшгүй гэдэг ёс суртахууны хувьд ч том цохилт авсан байна. Үүнийг олзлогдоод буцсан офицеруудаа цэр-

гийн шүүхийн тусгай зөвлөлгөөнөөр авч хэлэлцээд хүн тус бүрт ганц сумтай гар буу өгч өөрөөр нь өөрийг нь хороолгосон (332-р тал) явдал харуулж байна. Тэрчлэн 9-р сарын 7-ноос 11-р сарыг хүртлэх хугацаанд Японы Хуурай замын цэргийн жанжин штабын орлогч дарга Накадзима, Квантуны армийн ерөнхий командлагч Уэда, мөн армийн жанжин штабын дарга Исоя, 23-р дивизийн дарга Комацу Бара болон бас бус хүмүүсийг ажлаас нь халсан буюу тушаал бууруулжээ (326-р тал).

Гомигава Дзюньпей номынхоо төгсгөлд «хэлэлцээний үр дүн гэвэл хилийн шугамын дийлэнх хэсгийг эзлэх Халх гол ба Хайластын голын дагуу хилийн шугамыг Номонханы хэрэг явдал болохоос өмнө Зөвлөлт- Монголын талын баримталж байсны дагуу тогтоожээ. Тэр нь уг районыг хилийн шугам гэж түүхийн үүднээс заншиж ирсэн шугамтай бараг нийцсэн байна» гэж бичжээ (342-р тал). Эдгээр нотолгоо нь тухайн үед Япон улс түрэмгийлэгч байсан гэдгийг хүлээн зөвшөөрсөн хэрэг юм.

БНМАУ-ын нутагт 4 сар үргэлжлэсэн тэр дайн социализм ба империализмын хооронд болсон томоохон дайн бөгөөд тэр дайнд социализм, ардчилал, энх тайвны хүчин, тухайлбал Зөвлөлт, Монголын ах дүү арми, социализмын цэргийн шинжлэх ухаан ялсан юм.

#### **Д. Хүрэлтогоо**